



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

┌ Сургалтанд хамруулах тухай ┐

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 149 дүгээр тогтоолын хавсралт “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8, “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захиргаа, санхүү төлөвлөлтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Б.Алтан-Очирыг 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 хоногийн сургалтанд хамруулсугай.

2. Сургалтын зардал 80.000 /наян мянга/ төгрөгийг батлагдсан төсвийн хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч Г.Батнямд зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү төлөвлөлтийн хэлтсийн Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Т.Түвшинзаяад даалгасугай.

ДАРГА  М.ГОНЧИГЖАВ

3150600020